

ЗАДГАЙ ДААЛГАВАР

Тохирох залгаврыг зөв залган бичээрэй. /2 оноо/

1. $орох+оор=.....$

бодогд+но=.....

2. “Ертөнцийг гурван хар”-ыг дуурайн зохион бичээрэй. /3 оноо/

Тостойгоос тогоо хар

Бэлгэтэйгээс бэх хар

Амттайгаас архи хар

МАТЕМАТИК-СОНГОХ ДААЛГАВАР

1. Долоон мянга наян гурав гэсэн тоог стандарт хэлбэрээр зөв бичсэн хариуг олоорой. /1 оноо/

A. 8703

Б. 7803

В. 7083

Г. 3803

2. Зөвийг сонгоорой. /1 оноо/

A. $-5 > -6$


Б. $0 < -1$

В. $-2 = 2$


Г. $6 < 4$

3. Өгөгдсөн дүрсээс биетийг олоорой. /1 оноо/

A.




Б.



В.




Г.



4. Улаан өнгөнд дуртай хүүхдийн тоо нь шар өнгөнд дуртай хүүхдийн тооноос хэдээр цөөн бэ? /1 оноо/

Найзуудын дуртай өнгө



A. 6

Б. 8

В. 7

Г. 2

ЗАДГАЙ ДААЛГАВАР

1. Тохирох тоог нөхөж бич. /2оноо/

3л 859 мл = мл

9023 мл = лмл

2. Сувдаа найзуудаасаа ямар өнгөнд дуртайг нь асууж, мэдээллийг дараах хүснэгтэд бичжээ. Нийт хэдэн хүүхэд байсан бэ? /3 оноо/

Баганан диаграммыг зураарай.

Дуртай өнгө	Хүүхдийн тоо
Улаан	4
Шар	7



**ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 3-Р АНГИАС
АВАХ АНГИ ДЭВШИХ НЭГДМЭЛ АГУУЛГЫН ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

3.... ангийн сурагчовогтой

МОНГОЛ ХЭЛ

ХУГАЦАА: 40 МИН

БҮГД: 18 ОНОО

“Б” ХУВИЛБАР

Согоон цэцэг

Модон дотор ургадаг ягаан цэцэг хүн, мал ямар ч амьтны цусыг тогтооход хэрэглэдэг эмийн ургамал байжээ.

Анх удаа нээгдсэн эмийн ургамлыг “Согоон цэцэг” гэж нэрлэсэн нь гайхалтай. Дондогийг аавтайгаа ойд явж байтал модны чөлөөнд хоёр чоно согоо барьж байгаад хүний чимээгээр зугтаажээ. Согооны хүзүү, хонго их шархдсан харагдана. Шархтай согоо ойн цоорхойд очиж ягаан цэцэг түүж идэв.

Аав нь явахдаа хоёр мануухай босгож, согоог чононоос хамгаалжээ. Дондогийг “Согоогоо үзээд ир” гэж аав нь өдөр алгасалгүй явуулна. Арваад хоногийн дараа шархтай согоо эдгэрээд ойн гүнд явчихжээ.

СОНГОХ ДААЛГАВАР

1. Дондог ойд хэнтэй явж байсан бэ? /1оноо /

- А. ээжтэйгээ Б. аавтайгаа
В. ганцаараа Г. найзуудтайгаа

2. Шархадсан ямар амьтанг олж харсан бэ? /1оноо /

- А. чоно Б. үнэг
В. согоо Г. баавгай

3. Таних тэмдгийн тайлбарыг олоорой. 1оноо /



- А. Индүүдэж болохгүй Б. Өлгөж хатаана.
В. Индүүдэж болно Г. Гараар угаах ёстой

4. Хэн? гэсэн асуултад хариулагдах үгийг олоорой. 1оноо /

- А. согоо Б. ой
В. чоно Г. аав

1. Тохирох залгаврыг зөв залган бичээрэй. /2 оноо/
 явах+аар=.....

үзэгд+нэ=.....

2. “Ертөнцийг гурван хэцүү”-г дуурайн зохион бичээрэй. /3 оноо/

Туухад гахай нэг хэцүү

Туулахад тал нэг хэцүү

Тоолоход од нэг хэцүү.....

МАТЕМАТИК-СОНГОХ ДААЛГАВАР


1. Есөн мянга далан гурав гэсэн тоог стандарт хэлбэрээр зөв бичсэн хариуг олоорой. /1 оноо/

- A. 9703 Б. 9073 В. 3097 Г. 3079


2. Зөвийг сонгоорой. /1 оноо/

- A. $-3 > 4$ Б. $-2 < 1$ В. $-2 = 2$ Г. $4 < 3$

3. Тэгш хэм үүсэхгүй дүрсийг сонгоорой. /1 оноо/



4. Шар, цэнхэр өнгөнд дуртай нийт хэдэн хүүхэд байна вэ? Зөв хариултыг дугуйлаарай. /1 оноо/



- A. 5 Б. 7 В. 2 Г. 9

ЗАДГАЙ ДААЛГАВАР

1. Тохирох тоог нөхөж бич. /2оноо/

2кг 320 г = г

6083 кг = кг

2. Сувдаа найзуудаасаа ямар амтанд дуртайг нь асууж мэдээллийг дараах хүснэгтэд бичжээ. Баганан диаграммыг зураарай. Нийт хэдэн хүүхэд байсан бэ? /3 оноо/

Дуртай амттан	Хүүхдийн тоо
Зайрмаг	6
Чихэр	8



